

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ ХОРИНДӨРӨВДҮГЭЭР ХУРАЛДААН

Хуралдаан 2017 оны арваннэгдүгээр сарын 09-ний 10 цаг 50 минутад эхэлж, 11 цаг 47 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д 57 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах Комиссын танилцуулга /Удирдах албан тушаалд томилогдох нээлттэй сонгон шалгаруулалтын дүн, тайлан/	
2	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Зах зээл, судалгааны газрын даргын албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “а”, Сонгон шалгаруулах комиссын Д/57 дугаар дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн: Ренчингийн Сарантуяаг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Зах зээл судалгааны газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга /Б.Лхагва/-д санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.
3	Хөвсгөл аймгийн нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо нөхөх мэргэшлийн шалгалтын дүн	Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйл, Төрийн албаны зөвлөлийн Хөвсгөл аймаг дахь

		<p>Салбар зөвлөлийн 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 44 дүгээр тогтоол, төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 18 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 13 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх</p> <p>2. Энэхүү тогтоолын нэгд заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс гуравдугаар хавсралтад дурдсан хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 2 иргэн, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс дөрөвдүгээр хавсралтад дурдсан хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 3 иргэн, нийт 5 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх.</p> <p>3. Тогтоолын хоёрт дурдсан нэр бүхий 5 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг</p>
--	--	---

		баримтлан, тухайн албан тушаалд томилуулахыг Төрийн албаны зөвлөлийн Хөвсгөл аймаг дахь Салбар зөвлөл /Х.Ган-Очир/-д үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.
--	--	---

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБА**